



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/54/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Э.Нандинчимэг

Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗТХС	Зам Тээвэр Хөгжлийн Сайд
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БСШУСЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын



Агуулга

Аудитын гэрчилгээ	2
Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	8
2.14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Ауд.од. 27 № 172

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Цагаан-овоо сумын Соёлын төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Цагаан-овоо сумын Соёлын төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Цагаан-овоо сумын Соёлын төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан. Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520097



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Цагаан-Овоо сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч Ө.Лхамдорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаан-Овоо сумын Соёлын төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаан-Овоо сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 26-наас 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Цагаан-Овоо сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Цагаан-Овоо сумын Соёлын төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Иргэдэд соёлын үйлчилгээг хүргэх, хүртээмж нэмэгдүүлэх, соёлын үйлчилгээнд шинэлэг арга хэлбэрийг түгээн дэлгэрүүлэх”-д оршино.

Соёлын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ: Үүнд:

- Иргэд, ардын авъяастны дунд тэдний хэрэгцээ, сонирхолд түшиглэн соёл-чөлөөт цагийн олон талт ажлыг зохион байгуулах
- Байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, ардын авъяастныг түшиглэн үндэсний уламжлалт болон хүүхдэд зориулсан урлаг, сонгодог урлагийг сурталчлан дэлгэрүүлэх, хадгалж хамгаалах чиглэлээр сургалт явуулж, хамтлаг, хэсэг зохион байгуулан хүн амын соёлын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх
- Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Цагаан-Овоо сумын Соёлын төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Цагаан-Овоо сумын Соёлын төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Ахрloger” программ хангамж ашигладаг байна.

Цагаан-Овоо сумын Соёлын төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 38 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 74,923.5 мянган төгрөгөөс тооцон 1,498.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, гүйцэтгэлийн үе шатанд хэвээр баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Цагаан-Овоо сумын Соёлын төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,340.37 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	/ мянган төгрөг/
				Б
Авлага		9.45	9.45	
Бараа материал	25,306.87	26,031.07	724.20	
Үндсэн хөрөнгө	551,877.64	558,592.14	6,714.50	
Хуримтлагдсан элэгдэл	(37,533.62)	(64,322.14)	(26,788.52)	
Нийт хөрөнгө	539,650.89	520,310.52	(19,340.37)	
Өр төлбөр				
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	539,650.89	520,310.52	(19,340.37)	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	539,650.89	520,310.52	(19,340.37)	

Авлага дансны үлдэгдэл нь өсөлт нь Нийгмийн даатгалын сангаас авах авлагын дүн болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

ОНХОСангийн хөрөнгө оруулалтаар 6,600.0 мянган төгрөгийн хуурын иж бүрдэл, БСШУСЯамны хандиваар 114.5 мянган төгрөгийн ном хүлээн авснаар нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 520,310.52 мянган төгрөг болж 19,340.37 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 74,923.5 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 74,923.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 74,837.2 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байна.

Цагаан-Овоо сумын Соёлын төв 2019 онд өөрийн орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансанд 114.5 мянган төгрөгийн орлого орсон байна. Аж ахуйн материал, бичиг хэргийн материал худалдан авсан байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 38 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд эрсдэл тогтоож 31 эрсдэл тодорхойлж нийт 31 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 704.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 642.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 62.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө. Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Аудитаар дараах 642.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Санхүүгийн тайлан дээр өөрийн үйл ажиллагаанаас 114.5 мянган төгрөгийн орлого олсон боловч орлогын эх үүсвэрийг нотлох анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй байгаа нь ССайдын 2012 оны 276 тоот тушаал, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйл НББ-ийн анхан шатны баримт, 14 дүгээр зүйлд заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд гарсан зардлаас нийт 9,051.4 мян төгрөгийн зардал гарснаас 8523.7 мян төгрөгийн зардал бүртгэгдсэн байна. Зөрүү 527.7 мянган төгрөгийн



зардлыг ибаримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахв Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллалаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 62.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Кассын тайлан, билетийн тооцоо зэрэг бэлэн мөнгөний баримтуудын иж бүрнээр нь бэлтгэж байх. Орлогын эх үүсвэрийг тодорхой хөтлөн бүртгэлд тусгах.
2. Соёлын төв өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон жишиг НБББББ-г ашиглан боловсруулж санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглах

2.12. Шилэн дансны мэдээлэл

Цагаан-Овоо сумын Соёлын төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 146 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөвлөмжийг биелүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цагаан-Овоо сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Цагаан-Овоо сумын Соёлын төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХСайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтанд заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор шатахуун зарцуулалтыг дахин тооцоолоход 62.4 мянган төгрөгийн зөрүүтэй байсан.

1.2 Эрсдэл: Хөрөнгө арвилан хэмнэлт, үр ашиггүй зарцуулагдах.

1.3 Өгсөн зөвлөмж: Шатахуун зарцуулалтанд ЗТХСайдын 2019 оны 390 дугаар тушаалыг мөрдөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,306,872.00	26,040,517.25
33	АВЛАГА	-	9,445.25
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	9,445.25
35	БАРАА МАТЕРИАЛ	25,306,872.00	26,031,072.00
351	Түүхий эд материал	12,998,030.00	13,682,230.00
35110	Тусгай зориулалттай материал	12,998,030.00	13,682,230.00
354	Хангамжийн материал	12,308,842.00	12,348,842.00
35410	Бичиг хэргийн материал	12,308,842.00	12,348,842.00
2	ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН	514,344,019.89	494,270,003.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	514,344,019.89	494,270,003.24
392	Биет хөрөнгө	505,324,019.89	485,250,003.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	463,291,968.02	463,291,968.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(18,933,946.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,434,588.00	55,434,588.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,067,903.76)	(28,392,415.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,336,088.60	26,936,088.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,830,971.23)	(15,109,529.64)
39209	Зам, гүүрийн байгууламж	2,625,000.00	2,625,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(1,634,749.74)	(1,886,249.70)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,170,000.00	1,170,000.00
39217	Ном	-	114,500.00
393	Биет бус хөрөнгө	9,020,000.00	9,020,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,020,000.00	9,020,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	539,650,891.89	520,310,520.49
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	539,650,891.89	520,310,520.49
51	Засгийн газрын хувь оролцоо	539,650,891.89	520,310,520.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	325,295,610.20	325,295,610.20
51101	Өмч - төрийн	325,295,610.20	325,295,610.20
512	Хуримтлагдсан үр дүн	(108,894,365.73)	(128,234,737.13)
51210	Өмнөх үеийн үр дүн	(108,894,365.73)	(108,894,365.73)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(19,340,371.40)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	323,249,647.42	323,249,647.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	539,650,891.89	520,310,520.49

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	58,199,000.00	81,752,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,949,000.00	6,829,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,949,000.00	6,829,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,949,000.00	6,829,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,540,000.00	114,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,409,000.00	6,714,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	54,250,000.00	74,923,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	54,250,000.00	74,923,500.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	54,250,000.00	74,923,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	86,651,149.13	101,092,871.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,651,149.13	101,092,871.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,794,516.40	101,006,616.40
2101	Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	38,566,440.00	54,499,570.00
210101	Үндсэн цалин	38,566,440.00	54,499,570.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,876,622.00	6,792,756.75
210201	Тэтгэврийн даатгал	3,471,215.00	4,051,145.60
210202	Тэтгэмжийн даатгал	328,900.00	619,480.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	372,200.00	446,711.76
210204	Ажилгүйдлийн даатгал	78,100.00	385,213.97
210205	Эрүүл мэндийн даатгал	626,207.00	1,290,204.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,994,755.00	10,455,173.00
210301	Гэрэл, пахилгаан	1,306,155.00	1,362,766.00
210302	Түлш, халаалт	8,618,000.00	8,842,407.00
210303	Цэвэр, бохир ус	70,600.00	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	443,450.00	605,100.00
210401	Бичиг хэрэг	115,200.00	105,000.00
210402	Тээвэр, шатахуун	165,250.00	205,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	163,000.00	295,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,475,000.00	1,865,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,315,000.00	1,669,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210807	Газрын төлбөр	-	36,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,438,249.40	26,788,516.65
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,438,249.40	26,788,516.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,856,632.73	86,255.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,856,632.73	86,255.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,856,632.73	86,255.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)-(1)-(2)	(28,452,149.13)	(19,340,371.40)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(28,452,149.13)	(19,340,371.40)

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	56,790,000.00	75,038,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,540,000.00	114,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,540,000.00	114,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,540,000.00	114,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,540,000.00	114,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	54,250,000.00	74,923,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	54,250,000.00	74,923,500.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	54,250,000.00	74,923,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	56,790,000.00	75,038,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,790,000.00	75,038,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,785,097.00	74,951,745.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,970,392.00	54,484,161.00
210101	Үндсэн цалин	38,970,392.00	54,484,161.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,676,500.00	6,817,611.00
210201	Тэтгэврийн даатгал	3,118,200.00	4,484,343.00
210202	Тэтгэмжийн даатгал	328,900.00	545,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	372,200.00	260,168.00
210204	Ажилгүйдлийн даатгал	78,100.00	436,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	779,100.00	1,091,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,994,755.00	10,405,173.00
210301	Гэрэл, цахилгаан	1,306,155.00	1,362,766.00
210302	Түлш, халаалт	8,618,000.00	8,742,407.00
210303	Цэвэр, бохир ус	70,600.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	387,450.00	695,100.00
210401	Бичиг хэрэг	115,200.00	160,000.00
210402	Тээвэр, шатахуун	165,250.00	305,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	107,000.00	230,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,756,000.00	2,549,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,296,000.00	2,353,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210807	Газрын төлбөр	300,000.00	36,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,903.00	86,255.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,903.00	86,255.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,903.00	86,255.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	325,295,610.20	323,249,647.42	(108,894,365.73)	-	539,650,891.89
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	325,295,610.20	323,249,647.42	(108,894,365.73)	-	539,650,891.89
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	325,295,610.20	323,249,647.42	(108,894,365.73)	-	539,650,891.89
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	325,295,610.20	323,249,647.42	(108,894,365.73)	-	539,650,891.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	325,295,610.20	323,249,647.42	(108,894,365.73)	-	539,650,891.89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(19,340,371.40)	-	(19,340,371.40)
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	325,295,610.20	323,249,647.42	(128,234,737.13)	-	520,310,520.49

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74,923,500.00	74,837,245.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	74,923,500.00	74,837,245.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	74,923,500.00	74,837,245.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54,553,100.00	54,484,161.00
210101	Үндсэн цалин	54,553,100.00	54,484,161.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,819,700.00	6,817,611.00
210201	Тэтгэврийн даатгал	4,637,200.00	4,484,343.00
210202	Тэтгэмжийн даатгал	545,600.00	545,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	133,200.00	260,168.00
210204	Ажил үйлдлийн даатгал	412,400.00	436,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,091,300.00	1,091,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,406,600.00	10,405,173.00
210301	Гэрэл цахилгаан	1,515,000.00	1,362,766.00
210302	Түлц халаалт	8,741,600.00	8,742,407.00
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	708,000.00	695,100.00
210401	Бичиг хэрэг	160,000.00	160,000.00
210402	Тээвэр, шатахуун	308,000.00	305,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	240,000.00	230,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,436,100.00	2,435,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,240,000.00	2,239,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210807	Газрын төлбөр	36,100.00	36,000.00